



НИЙСЛЭЛИЙН БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 02 сарын 04 өдөр

Дугаар А/38

Улаанбаатар хот

Аян зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4, 9.5.2, 10 дугаар зүйлийн 10.2.10, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2009 оны 63 дугаар тогтоол, 2012 оны 61 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд нийтийн эзэмшлийн гудамж, зам талбай, гэр болон орон сууцны хорооллын цэвэрлэгээ үйлчилгээг сайжруулах, иргэдийн ая тухтай амьдрах цэвэр орчин нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор “Хоггүй шинэлээ” аяныг 2021 оны 02 дугаар сарын 05-ны өдрөөс 02 дугаар сарын 28-ны хооронд зохион байгуулсугай.


2. Аяныг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, ажлын төлөвлөгөөг хоёрдугаар, аяны удирдамжийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, нэгдсэн удирдлагаар хангаж, мэдээ тайланг 2021 оны 03 дугаар сарын 03-ны дотор Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанд хүргүүлэн ажиллахыг ажлын хэсэг /Б.Батбаяр/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Н.БАЯРМӨНХ

Баянзүрх дүүргийн Засаг даргын
2021 оны 02 дугаар сарын 09 -ны
өдрийн 439 дугаар захирамжийн
1 дүгээр хавсралт



АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДХҮҮН

Ажлын хэсгийн дарга:

Баянзүрх дүүргийн Дэд бүтэц, хот төлөвлөлтийн асуудал хариуцсан төслийн удирдагч

Гишүүд:

Баянзүрх дүүргийн Засаг даргын Тамгын газрын Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтсийн дарга

Баянзүрх дүүргийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга

Баянзүрх дүүргийн Засаг даргын Тамгын газрын Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтсийн дарга

Баянзүрх дүүргийн Засаг даргын Тамгын газрын Агаарын бохирдолтой тэмцэх тасгийн дарга

Баянзүрх дүүргийн Засаг даргын Тамгын газрын Хэвлэл мэдээллийн алба

Баянзүрх дүүрэг дэх Мэргэжлийн хяналтын хэлтсийн дарга

Баянзүрх дүүргийн Нийтлэг үйлчилгээний газар 1 ОНӨААТҮГ

Баянзүрх дүүргийн Нийтлэг үйлчилгээний газар 2 ОНӨААТҮГ

Баянзүрх дүүргийн Нийтлэг үйлчилгээний газар 3 ОНӨААТҮГ

Баянзүрх дүүргийн Нийтлэг үйлчилгээний газар 4 ОНӨААТҮГ

Баянзүрх дүүргийн Хороодын Засаг дарга нар

Нарийн бичгийн дарга:

Баянзүрх дүүргийн Засаг даргын Тамгын газрын Байгаль орчин, ногоон байгууламж хариуцсан мэргэжилтэн

Баянзүрх дүүргийн Засаг даргын
2021 оны 02 дугаар сарын 07 -ны
өдрийн 438 дугаар захирамжийн
2 дугаар хавсралт



ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хийгдэх ажил	Хугацаа	Хариуцах албан тушаалтан
1	Аяныг зохион байгуулах ажлын төлөвлөгөө гарган аж ахуйн нэгж, байгууллагууд хороодод хүргүүлэх	02 дугаар сарын 05	Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс
2	Хороодод үйл ажиллагаа эрхлэн явуулж буй төрийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагууд, иргэдэд цахим хэлбэрээр мэдээлэл хүргэх	02 дугаар сарын 05	Хэвлэл мэдээллийн алба, Хороодын Засаг дарга нар
3	Өөрийн болон туслан гүйцэтгэгч компанийн хог тээврийн бүх авто машинуудыг 1 хороонд 7 хоногт нэг удаа оруулж хог тээвэрлэлтийг хийх хуваарийг батлуулах	02-р сарын 05-наас 02 дугаар сарын 28-ныг хүртэл	Нийтлэг үйлчилгээний газар 1, 2, 3, 4 ОНӨААТҮГ
4	Хороодод үйл ажиллагаа эрхлэн явуулж буй сууц өмчлөгчдийн холбоо, аж ахуйн нэгж, байгууллага, айл өрхийн 50 метр хүртэлх талбай, гудамж хашааны хог хаягдлыг цэвэрлүүлэх ажлыг зохион байгуулах	Өдөр бүр тогтмол	Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс, Хороодын Засаг дарга нар
5	Хороодод байгаа үүсмэл болон хур хог хаягдлыг бүрэн цэвэрлэж, ачиж тээвэрлэх, нэмэгдэл машин техник гаргах ажлыг зохион байгуулах	Өдөр бүр тогтмол	Нийтлэг үйлчилгээний газар 1, 2, 3, 4 ОНӨААТҮГ
6	Хийгдэж байгаа ажлын явцын талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр иргэд, айл өрх, аж ахуйн нэгж байгууллагуудыг сурталчлах	Өдөр бүр тогтмол	Хороодын Засаг дарга нар, Хэвлэл мэдээллийн алба
7	Хийсэн ажлын мэдээг нэгтгэн нийслэл, дүүргийн удирдлагуудад танилцуулах	7 хоног бүр	Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс
8	Аяны хүрээнд хангалтгүй ажилласан аж ахуйн нэгж, байгууллага, хороодод хяналт шалгалт явуулж арга хэмжээ авч ажиллах.	Өдөр бүр тогтмол	Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс, Мэргэжлийн хяналтын хэлтэс

Баянзүрх дүүргийн Засаг даргын
2021 оны 02 дугаар сарын 03 -ны
өдрийн 138 дугаар захирамжийн
3 дугаар хавсралт



АЯНЫ УДИРДАМЖ

Нэг. Зорилго

Дүүргийн хэмжээнд нийтийн эзэмшлийн гудамж, зам талбай, гуу жалганд ил задгай үүссэн хогийн цэгийг цэвэрлэх, айл өрх, аж ахуйн нэгж байгууллагуудын эзэмшил хашаа, гудамж талбай хуримтлагдсан хог хаягдлыг цэвэрлүүлэх, ачиж тээвэрлэх, гэрлийн шон, хайс хашаанд наасан зар мэдээг хуулах нийтийн эзэмшлийн эд хогшил, хайс хамгаалалт, хөшөө дурсгал, гэрэлтүүлэг хогийн сав, сандлуудыг угааж цэвэрлэх, аж ахуйн нэгж, байгууллагуудын гадна хаяг, хаягийн байгууламжуудыг угаах, хог хаягдлын байгууллагуудын хог тээвэрлэлтийг эрчимжүүлэн иргэдийн хоггүй цэвэр орчинг бүрдүүлэх нөхцөлийг хангахад оршино.

Хоёр. Аян зохион байгуулах хугацаа:

2021 оны 02 дугаар сарын 03-ны өдрөөс 2021 оны 02 дугаар сарын 28-ны хооронд зохион байгуулна.

Гурав. Зохион байгуулж хамтран оролцох байгууллага.

Засаг даргын Тамгын газар хэлтэс, тасаг, дүүргийн Мэргэжлийн хяналтын хэлтэс, засаг даргын эрхлэх асуудлын хүрээний харьяаны байгууллага, хог хаягдлын үйлчилгээний байгууллагууд дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхлэн явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагууд, Сууц өмчлөгчдийн холбоод хороод хамтран оролцоно.

Хамтран оролцох хэлтэс, албад, хороодын хүлээх үүрэг:

№	Байгууллага	Хариуцах ажил
1	2	3
1	Засаг даргын тамгын газар	Дүүргийн хэмжээнд аяныг зохион байгуулах, олон нийтэд сурталчлах, харьяа төр захиргааны байгууллагуудыг оролцуулах.
2	Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс	Сууц өмчлөгчдийн холбоодын нийтийн эзэмшлийн явган замын хог хаягдал, орц шатны хонгил цэвэрлэх, гадна фасад хаяг, хана тааз угаах, орцны гэрэлтүүлгийг бүрэн болгох ажилд хяналт тавьж мэдээ тайланг агаарын бохирдолтой тэмцэх тасагт ирүүлэх
3	Хэвлэл мэдээллийн алба	Аян зохион байгуулах талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэх, цэвэрлэгээний ажлын явц үр дүнгийн талаар ТВ, радиогоор олон нийтэд хүргэх, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах.
4	Мэргэжлийн хяналтын хэлтэс	Аяны хүрээнд оролцож байгаа аж ахуйн нэгж, байгууллагуудад хяналт тавих, оролцоогүй байгууллагуудад мэдэгдэл, албан шаардлага хүргүүлэх, торгуулийн арга хэмжээ ногдуулах, үйл ажиллагааг түр хаах, согтууруулах ундаагаар үйлчилдэг аж ахуйн нэгж, байгууллагуудын тусгай зөвшөөрлийг хураах зэрэг ажлыг зохион байгуулах ба мөн түдгэлзүүлэх саналыг холбогдох байгууллагад тавих.

1	2	3
5	Хороод	Хороодын иргэд, Сууц өмчлөгчдийн холбоо, аж ахуйн нэгж, байгууллагуудад цэвэрлэгээ үйлчилгээний мэдээлэл хүргэх, цэвэрлэгээнд өргөнөөр хамруулах, гадна фасад, хаягийн байгууламжийг угаалгах, цэвэрлэж бөөгнүүлсэн, хог хаягдлыг шатаахгүй байх тал дээр онцгой анхаарч Нийтлэг үйлчилгээний газрын тус хороог хариуцсан байцаагч нартай хамтран тогтмол хяналт тавьж ажиллах, тайлан мэдээг илтгэх хуудсаар 7 хоногт 1 удаа Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэст THAAX.medee@gmail.com цахим хаягаар ирүүлэх.
6	Нийтлэг үйлчилгээний газар 1, 2, 3, 4 ОНӨААТҮГ	Аяны хүрээнд орон сууцны хороолол, дуудлагын аж ахуйн нэгж байгууллагуудын хог хаягдлуудыг шөнийн цагаар тээвэрлэх хуваарь гарган батлуулах, цэвэрлэгээнээс гарсан хог хаягдал, айл өрхийн хог хаягдлыг хурдан шуурхай ачиж тээвэрлэх, машин техникийг бэлэн байдалд байлгах.
7	Нийтлэг үйлчилгээний газар 1, 2, 3, 4 ОНӨААТҮГ	Нийтийн эзэмшлийн зам талбайн цэвэрлэгээ үйлчилгээг сайжруулах, зам дагуу байршуулсан хог хаягдлыг өдөр бүр ачиж тээвэрлэх. Орон сууц хороолол, чингэлэг хоорондох зай завсрын хог хаягдлыг цэвэрлүүлж мэдээ тайланг 7 хоног бүр Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэст THAAX.medee@gmail.com цахим хаягаар ирүүлэх.
8	Сууц өмчлөгчдийн холбоод	Сууц өмчлөгчдийн холбоод цэвэрлэгээний талаар нэгдсэн мэдээлэл, чиглэл өгөх, удирдан зохион байгуулан ажиллах, хариуцсан байрнуудын гадна орчин, орцны цэвэрлэгээг бүрэн хийлгэх, нийтийн эзэмшлийн авто замын тэмдэг, тоглоомын талбай, гадна фасад хаяг угаах, талбайн хог хаягдлыг цэвэрлэх ажлыг зохион байгуулан мэдээ тайланг Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтсийн СӨХ хариуцсан мэргэжилтэнд THAAX.medee@gmail.com цахим хаягаар ирүүлэх.

Дөрөв. Мэдээ тайлан ирүүлэх

1. Нийтлэг үйлчилгээний газар 1, 2, 3, 4 ОНӨААТҮГ болон хороод аяны явцын мэдээг 7 хоногоор гарган нэгтгэж, Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэст THAAX.medee@gmail.com цахим хаягаар ирүүлнэ.

2. Аяны эцсийн тайлан мэдээг 2021 оны 02 дугаар сарын 28-ны өдөр хийж гүйцэтгэсэн ажлын харьцуулсан фото зургийн хамт илтгэх хуудсаар Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэст ирүүлнэ.

3. Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэс хороодын мэдээ тайланг нэгтгэн Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанд 2021 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн 14:00 цагт эцсийн байдлаар явуулна.